

Орхоны хөндийн Хархорумын ойр орчин дахь хээр орших түүх соёлын үл хөдлөх дурсгалыг аялал жуулчлал, эдийн засгийн эргэлтэд оруулах нь

Бидэнд аялал жуулчлалын хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, эрдэм шинжилгээний болон онол-практикийн бага хурал, үзэсгэлэн, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах, гадаад орнуудаар аялж юм үзэж нүд тайлах, туршлага судлах ажил дутаагүй, гагцхүү дэвшүүлсэн зорилт, гаргасан зөвлөмжөө практикт нэвтрүүлэн амьд ажил хэрэг болгон үр дүнд хүргэж тэр бүр чадахгүй байна. Нэг үеэ бодвол манайд хот хоорондын хатуу хучилттай автомашины зам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн цахим сүлжээгээр хангагдаж, хувийн хөрөнгө оруулалттай орчин үеийн шаардлага хангасан зочид буудал, жуулчны баазуудын хүрэлцээ эрс сайжирсан.

Зөвхөн Хархоины хэмжээнд 30-аас дээш ортой тохилог зочид буудал 5, нийтдээ 1250 ортой жуулчны бааз 17 байна. Зарим өндөр зэрэглэлийн иж бүрэн тохижилттой өрөөнүүд бүхий жуулчны бааз, зочид буудал нь 200 суудалтай зоогийн газар, саун, фитнес, бассейн, бага хурлын болон сургалтын танхимтай. Гэтэл жуулчдын урсгал багаас тэдгээрийн ашиглалт хангалтгүй, анхны хөрөнгө оруулалтын зардлаа ойрын жилүүдэд нөхөх боломжгүй, алдагдал хүлээхэд хүрч байна. Өөрөөр хэлбэл аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжлөөс аялагч жуулчдад үзүүлэх тэдний сонирхол татах юмс, аялал жуулчлалын бүтээгдэхүүний тооны өсөлт хоцроод байна.



“Аса ланд” жуулчны бааз



Их хорум зочид буудал

Манай орон, аймаг, суманд газар сайгүй эртний хот, сүм хийдийн туурь, чулуун зэвсгийн үеийн бууц суурин, төмөр зэвсгийн үеийн дархны газар, тоосго шатаах, төмөр хайлуулах зуух, хүн амьдарч байсан агуй, оромж, чулуу, хүрэл, төмөр зэвсгийн үеийн ховор олдворууд, хөшөө, хаднаах бичээс, сүг зураг, булш хиргисүүр гээд аялал жуулчлалын элбэг нөөцтэй. Зөвхөн Хархоринд 71 ийм дурсгал бүртгэлтэй. Гэтэл энэ нөөцөө олигтой ашиглаж аялал жуулчлалын эргэлтэд оруулж үр шимийг нь хүртэж чадахгүй байна.



Гүмбийн дэнжийн буган чулуун хөшөө, хиргисүүрийн цогцолбор дурсгал



Бага нарийны аман дахь тоосгон өрлөгтэй, нуман хэлбэрийн 2 талдаа татах 7 суваг бүхий төмөрлөг хайлуулах зуух



Орхон голын хойд тал дахь Зараа хошууны хаднаах бичээс (хятад ханз, хүний дүрс)

Хамгийн гол нь жуулчдад үзүүлэх тэдний сонирхлыг татахуйц шаардлага хангасан объект-аялал жуулчлалын бүтээгдэхүүн цөөн байна. Энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалах боловч ерөнхий яриагаар хязгаарлалгүй гадаад, дотоодын том төсөл, төсвийн хөрөнгө оруулалт хөөцөлдөхийн зэрэгцээ аймаг, сумд, холбогдох байгууллагууд хамтран ажиллаж үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нутгийн иргэдийн идэвхтэй оролцоог ханган дотоод нөөцөө илрүүлэн ашиглаж бага гэлтгүй бүтээлч ажил өрнүүлэн аялал жуулчлалын хөгжилд тоо, чанарын ахиц

өөрчлөлт гаргууштай. Төсвийн санхүүжилт хүлээж суулгүй хөрөнгө шаардахгүй удирдлага зохион байгуулалтын наад заахын болон бүтээн байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлмээр байна. Аймаг, сум, байгууллага бүрт удирдлага-зохион байгуулалт, материал, санхүү, хүний шавхагдашгүй дотоод нөөц бололцоо бий. Гагцхүү ил, далд дотоод нөөц бололцоогоо илрүүлж бүтээлчээр тэр бүр ашиглаж чадсангүй. Иймд давын өмнө дараах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлмээр байна.

Нэг. Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох арга зүйн асуудал

Эхний ээлжид аяллын гол зам маршрутад ойр дөт байрлалтай, зорьж очиход зам харгуй саад бартаагүй, харьцангуй бага цаг хугацаа зарцуулах, түүх соёл, шинжлэх ухаан, аялал жуулчлалын хувьд өндөр үнэ цэнтэй цогцолбор дурсгалыг сонгон аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох цогц арга хэмжээ авч хэрэгжүүлмээр байна.

10 хавтгай км талбайд байрлалтай хөшөө дурсгалын тоо аль болох олон, нягтралтай байх нь чухал. Юуны өмнө дурсгал руу очих замын саад бартааг арилгасан, түүний эргэн тойрны орчныг тохижуулан явган аяллын маршрутыг зураглан, үзэх объектуудын нэрийг бичсэн, зорих газарт хүрэх замын зүг чиг, зайг заасан болон анхааруулж сэрэмжлүүлсэн тэмдэг, тэмдэглэгээтэй, машины олон салаа замыг цэгцэлж, замбараагүй хөдөлгөөнийг хязгаарласан авто зогсоолтой, аялагч жуулчид чөлөөтэй зорчин дурсгалыг үзэхэд аюул осол, саад тотгоргүй тааламжтай нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Тухайн дурсгалын дэргэд монгол, англи хэл дээр бичсэн тайлбар танилцуулга бүхий чанар, гоо зүйн шаардлага хангасан самбар байрлуулахын зэрэгцээ олон жуулчид ирж сонирхдог дурсгалын ойролцоо орон нутгийн соёлын өвд суурилсан бэлэг дурсгалын зүйлс худалдаалахад зориулсан талбай байгуулах зэргээр иж бүрэн тохижуулах хэрэгтэй байна.

Автомашин хөдөлгөөн ихтэй, хүний зүй бус үйлдэлд өртөх өндөр эрсдэлтэй эзэнгүй хээр газарт байрласан дурсгалуудын хамгаалалтын хайс, танилцуулга самбарт тавих техникийн шаардлага нь төв суурин газарт байрлалтай, олон

нийтийн өдөр тутмын хараа, хяналт дор байдаг дурсгалуудынхаас харьцангуй өндөр бөгөөд хамгаалалтын хайс, танилцуулга самбар нь байгалийн элдэв гамшиг, агаарын хүчтэй урсгалын даралт, хуй салхи, хүн, малын сөрөг нөлөөллөөс бүрэн хамгаалахуйц бөх бат, түүний зай талбай, өндөр намын хэмжээ нь аялагч жуулчид үзэж сонирхох, гэрэл зураг авахад саад тээг болохооргүй загвар хийцтэй байх ёстой.



Дурсгалын дэргэдэх танилцуулга самбарууд



ДӨ-ОХСДГ-ын хамгаалалтын бүсийн хилийн боржин чулуун багана

Дурсгалын дэргэд жуулчдад зориулсан бэлэг дурсгалын зүйлсийн худалдаа, үйлчилгээ эрхлэгч, жуулчны баазуудын ажилтнууд, ойролцоо нутагладаг малчид, лам хуваргууд, сүсэгтэн олны төлөөлөл зэрэг ашиг сонирхлоороо нэгдсэн нутгийн иргэдийн өргөн оролцоотой дурсгал хамгаалах, ашиглах нөхөрлөлүүдийг байгуулж тэдгээрийг мэргэжил- арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллуулбал тус нэмэр болох нь дамжиггүй.

Хоёр. Аялал жуулчлал нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн түүх соёлын дурсгалыг хамгаалах шалгарсан арга хэрэгсэл мөн.

. ОХУ зэрэг зарим улс орнууд түүх соёлын дурсгалыг хамгаалах, ашиглах нэгдсэн нэг хуультай. Гэтэл манайд энэ харилцан бие биеэ нөхцөлдүүлсэн хоорондоо салшгүй холбоо, хамаарал, шүтэлцээтэй ажил, асуудлууд салангид байгааг

анзаарч анхаарч үзэхэд илүүдэхгүй. Аялал жуулчлалд оролцогч компаниуд, нутгийн иргэд орлого ашгаа нэмэгдүүлэхийн тулд бизнесийн эх сурвалж болох түүх соёлын дурсгалаа хадгалж хамгаалах талаар байнга санаа тавьж түүнд хөрөнгө оруулах нь зүйн хэрэг. Компаниуд хариуцлагатай аялал жуулчлал эрхлэх учиртай.

Аливаа үл хөдлөх дурсгал нь хүрээлэн буй байгаль орчинтойгоо зохицолдсон байдаг учир түүний байрлуулсан газрын хөрсийг элдэв төрлийн эвдрэлд оруулж унаган төрхийг нь алдагдуулбал тухайн дурсгалын үнэ цэн буурдгийг санууштай. Жуулчдын аяллын замд нүдэнд тусах онгон зэлүүд байгаль, танан цагаан гэрүүд, тал толгод дүүрэн багширсан мал сүрэг зэрэг юм бүхэн ариун тансаг сайхан харагдаж байж тэдний сэтгэлийг сэргээх учиртай. Байгаль, соёл нь хоорондоо хүйн холбоотой тул байгаль, соёлын хосолмол аялал жуулчлал(ecological and cultural mixed tourism)-хөгжүүлэх, тэдгээрийг салангид биш хамтад нь авч үзэх шаардлагатай. Аялагч жуулчид онгон байгаль, эх төрх байдлаа хадгалж бүрэн бүтнээрээ байгаа түүх соёлын дурсгалыг илүү сонирхож сэтгэлийн таашаал авдаг.

Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар(ДӨ-ОХСДГ)-ын хамгаалалтын захиргаа дээрх шаардлагыг бүрэн хангасан хамгаалалтын хайс, танилцуулга самбарыг хийж жуулчид ихэд сонирхдог 10 гаруй дурсгалын дэргэд байрлуулав. Мөн Хархорум хотын туурийн хамгаалалтын бүсийн нүүрэн талд Эрдэнэ зуугийн хэрэмний баруун хойд захаас залгуулан 260 метр урт хамгаалалтын хайс хийж тавив. Түүнчлэн Хархорины сор үзмэрүүдэд тооцогдох, түүх соёл, аялал жуулчлалын хувьд өндөр үнэ цэнтэй “Эрхтэн чулуун хөшөө” дурсгалыг үер усны аюулаас хамгаалах техникийн арга хэмжээ авч түүнийг иж бүрэн тохижуулсны зэрэгцээ “Монголын эртний болон дундад зууны эзэнт гүрнүүдийн хөшөө-дурсгал”-ын гадна талд танилцуулга самбар, тусдаа байрлалтай гурван байгууламжийн дотор талын хананд нь түүнтэй холбоотой түүхэн баримтуудаар үзүүлэнгүүд хийж байрлуулан музейжүүлэв. Сумын Засаг даргын тамгын газар энэ объект руу цахилгаан дамжуулах шугам тавьж, түүний дотор, гадна талд байрлуулсан үзмэрүүд, тэдгээрийн тайлбар танилцуулга, жуулчид зорчих зам, шат, автозогсоолыг гэрэлтүүлэгтэй болгон тэд зам зуураа түр саатан амрах хэд хэдэн

сүүдрэвч хийж сандал ширээ, хогийн савууд байрлуулан түүнийг үе шаттай тохижуулах ажлыг эхлүүлээд байна.



Эрхтэн чулуун хөшөө дурсгалын үерийн усны хамгаалалт, орчны тохижуулалт

“Монголын эртний болон дундад зууны эзэнт гүрнүүдийн хөшөө-дурсгал”-ыг музейжүүлснийг харуулсан гэрэл зургууд






Мөн НҮБ-ын ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооноос Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь нийт хүн төрөлхтний тусын тулд хамгаалбал зохих хосгүй гайхамшигт түгээмэл үнэ цэнтэй болохыг нотлон түүнийг дэлхийн өвийн жагсаалтад 2004 онд бүртгэсэн тухай түүхэн баримтыг харуулсан болон Орхоны хөндийн томоохон түүх соёлын дурсгалыг алсаас ажиглах харууц газрын дэргэд монгол, англи хэлээр бичсэн тайлбар бүхий самбарыг Мэлхийт толгойн орой дээр байрлуулав. Мөн хөтөч-тайлбарлагчдад зориулан тэдгээр үзмэрүүдийн тайлбар, танилцуулгын агуулга, үзүүлэх дэс дараалал, арга зүйг боловсруулан тэдэнд түгээж байна.




Мэлхийт толгойн орой дээрх түүхэн баримт бичиг, харууц газрын танилцуулга самбар

Жуулчдад үзүүлэх объектын тайлбар, танилцуулгын агуулга, арга хэлбэр нь тэдний танин мэдэхүйн сонирхлын өдөөлт, таашаал, сэтгэл ханамжийн түвшинд шууд нөлөөлдөг учир “Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хүн төрөлхтний соёлын өвийн хосгүй гайхамшигт, түгээмэл үнэ цэнэ”, “Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар дахь соёлын үл хөдлөх дурсгалууд”, “ Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар дахь аялал жуулчлал” гэсэн олон нийтэд болон хөтөч-тайлбарлагч нарт зориулсан ном, гарын авлага, өөрийн байгууллагын Дэлхийн өвийн хорооны удирдамжийн дагуу гүйцэтгэсэн бүтээн байгуулалтын ажлын үр дүнд тулгуурлан бичсэн “Хээр орших түүх соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалт, ашиглалтын менежмент” товхимол, “Дэлхийн өв-Орхоны хөндийн түүх соёлын зарим дурсгалууд” зурагт хуудас зэргийг хэвлэн гаргалаа. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх төслүүдийг аймаг, сумын удирдлага, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” төслийн багаас дэмжин санхүүжүүлсэн юм.



Аялагч жуулчид ДӨ-ОХСДГ-ын аяллын ерөнхий маршрут, Орхон голын хойд, урд талаар аялах хоёр тусдаа маршрут, Хархорин орчмын болон Хархорин-Шанх-Хужирт чилэлийн аяллын маршрутуудын дагуу зорчдог. Аяллын маршрутуудын зураглалыг доор үзүүлэв.



Зорих газрын менежмент(destination management)-эд шинжлэх ухаанчаар хандан ялангуяа томоохон объектуудыг иж бүрэн тохижуулах хэрэгтэй. Ташрамд дурдахад Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг дэлхийн өвд бүртгүүлсний давуу талыг аялал жуулчлалд үр дүнтэй ашиглахад төв орон нутгийн төр захиргаа,

соёл, боловсрол, аялал жуулчлал, эрдэм шинжилгээний зэрэг байгууллагуудын санаачлагатай бүтээлч хамтын үйл ажиллагаа хангалттай биш байна.

Шинжлэх ухааны байгууллагууд, аялал жуулчлалын салбарын эрдэмтэн судлаачид, нэн түрүүнд археологичид судалгаа шинжилгээ, малтлага хийн олж илрүүлсэн олдворууд, эд өлгийн зүйлсийн он цагийг тогтоон эрдэм шинжилгээний тодорхойлолтыг аль болохоор алгуурлалгүй боловсруулан аялал жуулчлалын эргэлтэд оруулах талаар санал дүгнэлт,


арга зүйн зөвлөмжөө музей, соёлын өвийг хамгаалах байгууллагуудад өгч байх, түүх соёлын объектуудыг аялал жуулчлалд ашиглах хэрэглээний шинжлэх ухааны судалгааг түлхүү хийн үр дүнд хүргэн практик зорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд илүү анхаарал тавимаар байна.

Ойрын жилүүдэд Хархорум хотын тууриас илрүүлсэн томоохон олдворуудыг түшиглэн ил музей мөн угсаатны зүйн бэсрэг музей байгуулах нь хойшлуулшгүй шийдвэрлэбэл зохих асуудал мөн.

Нүүдэлчдийн ахуй соёлтой танилцах аяллыг зохион байгуулахдаа жуулчдыг зөвхөн айлаар оруулснаар хязгаарлаж болохгүй. Хот айлд мал маллагаа, эдэлгээний тоног хэрэгсэл, төрөл бүрийн арьс шир, ноосон эдлэл, борц, цагаан идээг гараар үйлдвэрлэх, ашиглах уламжлалт арга технологийг дэлгэн үзүүлсэн аялал жуулчлаын иж бүрэн бүтээгдэхүүнийг бий болгон нэг дор танилцуулах, аялал жуулчлалын гол маршрутын дагуу нутагладаг айл өрхийг сонгон авч зуслан, хаваржаа, намаржааны нутгийн байршлыг харилцан тохиролцон олон жил дагаж хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж тэдэнд зохих хэмжээний хөлс урамшуулал өгөн идэвхжүүлэн тэнд зориуд гадаад хэлний мэдлэг боловсрол сайтай тайлбарлагч ажиллуулбал үр дүнд хүрнэ. Гадаадын жуулчид монгол гэр барих, буулгах, түүнийг ердийн хөсөгт ачиж зөөвөрлөхийг ихэд сонирхдог. Аливаа үнэгүй буюу хямд ажил, үйлчилгээ чанаргүй байдаг. Гадаадын жуулчид гэрийн нөхцөлд уламжлалт аргаар бэлтгэсэн монгол үндэсний сүү, өрөм, бяслагийг төдийлэн идэхгүй амсаад өнгөрдөг.

Харин тэд үйлдвэрлэлийн аргаар боловсруулж ариутган савласан сүү, тараг, нягт шахалттай давс бага зэрэг амтагдсан бяслаг, исгэлэн амттай цөцгий, өндөр чанарын найрлага, хольцтой хиама, гахай, шувуу, загасны мах идэж уух дуртай. Жуулчид борц, горхгийг хийдэг өвөрмөц арга технологийг ихэд сонирхохын сацуу амтархан идэх дуртай. Энэ бүгдийг аль болохоор орон нутгаас зохион байгуулалттай жуулчны бааз, зочид буудал, зоогийн газруудад нийлүүлэн жуулчдад иж бүрэн үйлчилгээ үзүүлж байж айл өрх, иргэдийн аялал жуулчлалаас олох орлогын хэмжээ нэмэгдэнэ.

Гурав. Аялал жуулчлалын менежментийн тухайд



ЮНЕСКО, Дэлхийн өвийн хороо, Олон улсын музейн зөвлөл, Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын вебсайтуудад байршуулсан соёлын өвийн хамгаалалт, ашиглалт, соёлын аялал жуулчлалд холбогдох олон улсын дүрэм, удирдамж, зөвлөмж болон зарчмууд, арга зүйн зөвлөгөө, төрөлжсөн гарын авлагууд, ном

хэвлэл, гадаад орнуудын арга туршлага, шинэ чиг хандлага, жишиг загварыг сайтар судлан үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал “Олон улсын соёлын аялал жуулчлалын дүрэм” гэж бий. Иймд Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаанаас эрхлэн “Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад холбогдох ЮНЕСКО-ын зарим дүрэм, удирдамж, зөвлөмж болон зарчмууд”-ыг англи хэлнээс орчуулан олон нийт, ажил үйлс нэгт соёлын ажилтнуудад зориулан хэвлүүлэв. Тэр бүгдийг орчуулан хэвлэх санхүү, хүний нөөцийн хөтөч боломж хомс тул холбогдох байгууллагуудын ажилтнуудын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд тавих шаардлагыг өндөржүүлэх шаарлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ бодит хэрэгцээг харгалзан ДӨ-ОХСДГ-ын хамгаалалтын захиргаанаас эрхлэн өөр хоорондоо салшгүй холбоотой, харилцан хамааралтай соёлын болон байгалийн өв, музей, аялал жуулчлал, өвийн хамгаалалт, ашиглалтын менежмент, маркетингтай холбоотой мэргэжлийн идэвхтэй үг хэллэгийг нэг дор оруулсан англи-монгол толь бичгийг зохион хөтөч-тайлбалагчид болон олон нийтийн хүртээл болгоод байна. Орчин үед аялал жуулчлалын менежмент, маркетингийг шинжлэх ухааны үндсэн дээр хөтлөн явуулах шаардлага тавигдсаар байна. ЮНЕСКО, Дэлхийн өвийн хороо, Дэлхийн аялал жуулчлалын байгууллага олон улсын практикт нэгэнт үр ашигтай болох нь нотлогдсон, аялал жуулчлалд оролцогч талуудын хамтын менежмент (co-management)-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг чухалчлан үздэг. Иймд аялал жуулчлалын үйлчилгээний

байгууллагуудын үйл ажиллагааг хооронд нь уялдуулан зохицуулж нэгдсэн удирдлагаар ханган нэгдмэл цогц болгосон цагт аль ч тал нь хохирохгүй харин эцсийн дүндээ бүгдээрээ хожиж үр дүнд хүрэх нь лавтай.

Өөрөөр хэлбэл, төв, орон нутгийн төр захиргааны байгууллага, аялал жуулчлал эрхэлдэг амралт сувилал, жуулчны бааз, зочид буудал, зоогийн газар, музей зэрэг үзвэрийн газрууд, ДӨ-ОХСДГ, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газруудын хамгаалалтын захиргаад, тээврийн үйлчилгээний байгууллагууд, тур оператор, турагентууд амин хувиа хичээн тус тусдаа салангид бус нэгэн зорилгын дор нягт хамтран ажиллал аялагч жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлж тэдний сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлж чадна.



Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, одоо ерөнхийлөн ярихаа багасган тодорхой бүтээлч ажлыг өрнүүлэн байгууллага, ажилтны үйл ажиллагааны гүйцэтгэлийг эцсийн үр дүнгээр нь дүгнэх, үр өгөөжтэй санал, бүтээлч санаачлагыг бага гэлтгүй урамшуулах, хөхиүлэн дэмжиж тэдэнд байнга эрэл хайгуул хийдэг дадал эзэмшүүлэх шаардлагатай.

Аялал жуулчлал нь улс, орон нутаг, иргэдэд валютын орлого оруулахын зэрэгцээ ажлын байр бий болгох, байр сууц, хоол хүнс, тээвэр, соёл урлаг, эрүүл мэнд, төрөл бүрийн спорт, ан агнуур, худалдаа, уналгын морь, тэмээ эзэмшигч, бэлэг дурсгал, орон нутгийн гар урлалын бүтээгдэхүүн борлуулагч, эвент арга хэмжээ зохион байгуулагч, газарч, хөтөч-тайлбарлагч, орчуулагчийн зэрэг төрөл бүрийн үйлчилгээ үзүүлсний төлөө шууд ба шууд бус орлого оруулж төв, орон нутгийн хөгжил, хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд томоохон хувь нэмэр оруулдаг. Нутгийн соёлын болон байгалийн өвд суурилсан бэлэг дурсгалын зүйлс нэмүү хийхийг эрмэлзэх хэрэгтэй.

БНХАУ-ын хөдөөгийн тосгонууд орон нутгийн онцлог, давуу тал, нөөцийг ашиглан нутгийн иргэдийн идэвхтэй оролцоонд түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнүүдийг бий болгон хүн амаа ядуурлаас гаргаж байгаа бодит жишээ баримт олон бий. Жуулчны баазуудыг орон нутгийн төсөв, санхүүгийн байгууллагуудтай шууд харилцдаг болгох шаардлагатай. Дотоод, гадаадын аялагч, жуулчдын сонирхлын ялгааг харгалзан үзэж тэдэнд зориулсан зарим аяллын маршрутууд өөр өөр байж болно.

Жишээлбэл, Хархоринд чацаргана, үхрийн нүд, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, болон төрөл бүрийн мод тарьж үржүүлдэг “Хархорин” ХХК-ыг түшиглэн агро буюу хөдөөний аялал жуулчлал зохион байгуулах, Монголын анхны овор багатай усан цахилгаан станц, толгойн боолт, усжуулалтын суваг, иргэн Ганбаатарын ногоон байгууламж, амьтны бичил хүрээлэн, иргэн О. Ангарагсүрэнгийн угсаатны зүйн музейн эд өлгийн зүйлсийн цуглуулгыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж дотоодын жуулчдын аяллын маршрутад оруулан үзүүлэх боломж бий.



Томоохон болон аялал жуулчлалын хувьд үнэ цэнтэй зарим дурсгалт объектууд(Төвхөн хийд, Хархорум хотын туурь, Мэлхийт толгой, Монголын их гүрнүүдийн хөшөө зэрэг)-ийг жуулчдад үзүүлэхэд тасалбар түгээн хэр тааруу хураамж авч тухайн дурсгалуудын хамгаалалт, ашиглалттай холбоотой зарим зардлыг санхүүжүүлдэг байж болох юм. Өөрийн аймаг, сумаар хязгаарлалгүй улсын хэмжээний аялал жуулчлалын гол маршрутуудын дагуу орших аймаг, сумдтай аялал жуулчлалын үйл ажиллагааг уялдуулан зохицуулбал үр өгөөжтэй байх талтай. Аялал жуулчлалын бүс нутгууд, дэлхийн өвийн болон байгалийн цогцолборт газрууд, аймаг, сумдын хооронд аялал жуулчлалд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах өрсөлдөөн улам бүр нэмэгдэж Хөвсгөл, Хэнтийн чиглэлд Азийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар аялал жуулчлалын томоохон төслүүд хэрэгжиж эхлээд байна. Ийм бодит нөхцөл байдал нь та биднээс энэ чиглэлд шинэ хандлага, санаачлага, идэвх чармайлт гарган байнгын эрэл хайгуул хийж бүтээлчээр ажиллахыг зүй ёсоор шаардаж байна. Аялал жуулчлал эрхлэгчид байгальд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, соёлын өвд суурилсан, хариуцлагатай , тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд иж бүрэн хандах арга барилыг эзэмшихэд ихээхэн хүч чармайлт гаргах хэрэгтэй байна.

ДӨ-ОХСДГ-ын хамгаалалтын захиргааны ажилтан магистр Н.Чимиддорж